

МОНГОЛБАНК-нд

“Ариг банк” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Түвшинтамирын

2023 оны 04 дүгээр улирлын ажлын тайлан

2024 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Миний бие Д.Түвшинтамир нь “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын болон Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллаа.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хурлууд, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын болон бусад хорооны хуралд оролцож холбогдох хурлыг удирдаж, тогтоолын төсөл, шийдвэр, дүгнэлт, асуудалд саналаа өгч ажилласан. Хүснэгтээр харуулбал:

Хуралд оролцсон байдлаар №1:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Аудитын хорооны хурал	Эрсдэлийн хорооны хурал	Нийт оролцсон хурал
1.	-	6	3	3	12

Хурал хуралдсан огноогоор №2:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Аудитын хорооны хурал	Эрсдэлийн хорооны хурал
1.	-	2023-10-24 2023-10-30 2023-11-03 2023-12-04 2023-12-14 2023-12-25	2023-11-03 2023-11-29 2023-12-15	2023-10-13 2023-10-25 2023-11-29

Хараат бус гишүүнээр хуралд заавал санал өгсөн байдлаар №3:

№	Сонирхлын зөрчилтэй асуудал	Их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал
1.	6	1

Тайлант хугацаанд танхимаар буюу биечлэн оролцох хуралд 100% ирцтэй ажиллаж 4 удаа хуралдсан, эчнээ санал хураалтаар 2 удаа санал өгсөн бөгөөд 3 удаад Аудитын хорооны хурлын даргаар 3 удаа Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажиллаж, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцсэн.

ТУЗ-ийн гишүүний хувьд:

1. Банкны 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэх,
2. ТУЗ-ийн хуралд 100% ирцтэй оролцож нийт 14 асуудал хэлэлцэж, санал, дүгнэлтээ өгсөн,

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчил үүсэж болзошгүй 6 удаагийн хэлцэлд саналаа өгсөн. Санал өгөөгүй хэлцэл байхгүй. 6 удаагийн зөрчил үүсэж болзошгүй хэлцлийг ангилж харуулбал:

1. Холбоотой этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах 6 тохиолдол тус тус байна. Үүнд: 6 сонирхлын зөрчилтэй хэлцлийн 1 хэлцэл нь өмнө нь ТУЗ-р шийдвэрлэсэн хэлцэл байсан нь Номин Их дэлгүүрт банкны салбар, тооцооны нэгж байгуулахтай холбоотойгоор талбайн ашиглалтын хэмжээнд өөрчлөлт орсон тул дахин ТУЗ-р шийдвэрлүүлэхээр оруулж ирсэн. Гэрээний байршил болон төлбөрийн нөхцөлд ямарваа нэгэн давуу байдал үүсээгүй учраас дэмжсэн санал өгсөн болно.
2. “Номин даатгал” ХХК-тай байгуулсан гэрээг дахин 1 жилээр сунгах, ажилчдын болон банкны үл хөдлөх, хөрөнгийг даатгах гэрээг дахин нэг жилээр сунгасан. Сунгахдаа ижил төрлийн үйлчилгээ эрхэлдэг 4-5 даатгалын компанитай харьцуулан шийдвэр гаргасан.
3. Үлдсэн 4 сонирхлын зөрчилтэй байж болох асуудал нь хувьцаа эзэмшигч “Улаанбаатар Импэкс” ХХК, түүний хувь эзэмшигч, тэдгээрийн эцсийн өмчлөгчтэй холбоотой гэж үзсэн учраас уг асуудлыг ТУЗ-ийн хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй этгээдүүд санал өгсөн. Ийнхүү 3 хараат бус гишүүн 100% санал нэгтэйгээр “Номин Трейдинг” ХХК-ийн “Номин Моторс” ХХК, “Флай эдвэнчурс” ХХК, “Опен Адвенчурс” ХХК-тай зээлийн бүтээгдэхүүнээр хамтран ажиллах гэрээ байгуулах, хавсралтад дурдсан нөхцөлийн дагуу гэрээ байгуулах эрхийг банкны Гүйцэтгэх захиралд олгов. Гэрээний нөхцөл нь ямар нэг давуу байдал огт олгоогүй, судалгаа хийсэн нотлох баримтуудтай байсан нөхцөл байдлыг энд дурдах нь зүйтэй.
4. Их хэмжээний хэлцэлд Гүйцэтгэх захирлын эрх мэдэл хэдий байсан ч гэсэн Монгол Улсын Засгийн газрын бонд барьцаалах анхны тохиолдол учраас ТУЗ-р баталгаажуулахаар хэлэлцүүлсэн. ТУЗ-ийн бүх гишүүд хэлцэл байгуулахыг зөвшөөрсөн. Уг хэлцэл хийгдээд 7 хоногт бүрэн хэрэгжиж хаагдсан. Энэ үйл явцад хараат бус гишүүний хувьд байнгын хяналт тавьж ажилласан болно.

Дээрх хэлцлүүд бүгд харьцуулсан судалгаатай ба сонирхлын зөрчилгүй гишүүд 100%-ийн саналтайгаар шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргын хувьд:

1. “Ариг банк” ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газраас 2023 оны 03 дугаар улиралд Тусгай активын хэлтэс, Эрсдэлийн удирдлагын газар, УИД салбарын зээлийн үйл ажиллагаанд тус тус хийсэн шалгалтын тайлантай танилцаж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэн шийдвэр гаргасан.
2. Мөн банкны “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-д дахин сайжруулалт хийж, ТУЗ-өөр хэлэлцүүлэн баталсан.
3. Дотоод аудитын газраас хийсэн шалгалтын дагуу банкны газар, хэлтэс, салбар тооцооны төвүүдэд 2023 оны 01,02,03 дугаар улиралд хийж гүйцэтгэсэн шалгалтын тайлантай тухай бүр танилцаж, хорооны хурлаар хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгснөөс

гадна шалгалттай холбоотой хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлаж, холбогдох албан тушаалтануудад хүргүүлэх даалгаврыг ДАГ-т өгч ажилласан.

4. Банкны 2023 оны санхүүгийн тайланд хийх хөндлөнгийн аудитын байгууллагаар Ernst & Young LLC-г сонгон шалгаруулж холбогдох гэрээ хэлцлийг хийж, шалгалтын удирдамжийг баталж, аудит оруулан хэвийн ажиллах нөхцөлөөр ханган ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүний хувьд:

1. Эрсдэлийн удирдлагын газарт хийсэн иж бүрэн шалгалтын тайлантай танилцаж, холбогдох шийдвэр гаргаж, санал дүгнэлтээ өгч, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлав.
2. Банкны Тусгай активын хэлтэст хийсэн иж бүрэн шалгалтын тайлантай танилцаж, холбогдох шийдвэр гаргаж, санал дүгнэлтээ өгч, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлав.
3. Чанаргүй зээл барагдуулах ажиллагаа, үүсэж буй эрсдэлт хүчин зүйл, түүнийг бууруулах талаар хууль эрх зүйн зөвлөгөөг ТУЗ болон хорооны хурал дээр илүү түлхүү өгч, өөрийн санал, зөвлөмжийг өгч ажилласан.

Миний бие ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд дараах зарчим, зорилтуудад Банк анхаарлаа хандуулж байгааг онцлон хэлмээр байна.

- ТУЗ-ийн үйл ажиллагаа нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгуулагаас гаргасан дүрэм журмын дагуу тогтмол, идэвхтэй хуралдаан хэлбэрээр явагдаж байна.
- Монголбанкнаас Банк болон ТУЗ-д ирүүлсэн мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлж эргэн тайлагнадаг.
- ТУЗ-өөс засч сайжруулах шаардлагатай асуудлууд байгаа тохиолдолд бид ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын түвшинд хэлэлцүүлгийг эхлүүлж, холбогдох хяналтыг тавьж, үйл ажиллагааг нь хэрхэн сайжруулах талаар удирдамж, үүрэг даалгавар өгч, эргэн тайлагнах хугацааг зааж өгдөг. Гүйцэтгэх удирдлагын баг ТУЗ-өөс хүргүүлсэн удирдамж, үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлсэн, ямар шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авсан эсэх талаар эргэж тайлагнаж хэвшсэн.
- Тайлангийн хугацаанд Банкны хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөхүйц буруу зүйл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал зарлах шаардлага гаргаагүй болохыг дурдья.
- ТУЗ нь гаргасан шийдвэрүүд болон тэдгээрийн үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухай бүр нийтэд мэдээлдэг.
- ТУЗ-ийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй бөгөөд хэрэв надад асуулт байгаа эсвэл нэмэлт тодруулга авах шаардлагатай бол ТУЗ болон Удирдлагын багаас зохих мэдээллийг авдаг.
- Мөн эдгээр хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.
- Тайлангийн хугацаанд ТУЗ-өөс гаргасан бүх шийдвэрийн санал хураалтад оролцохдоо миний зүгээс сайтар судалж, дэмжсэн гэдгээ илэрхийлж байна.


Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус

Гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу ажлын тайлангаа тайлагнав.

ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх хороодын зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж байгаагийн сацуу Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан хараат бус гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэн бие даасан, хараат бус, мэргэшсэн байх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Тайлан бичсэн:

"Ариг банк" ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга,
Эрсдэлийн удирдлага болон Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүн
Д.Түвшинтамир



/гарын үсэг/